

БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш. БАЯНМОНХ  
*Ш. БАЯНМОНХ*

ЗУУХ №3-ЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

9020030414 дк. 6021646

1116218734 №. 6050794  
БАТЛАВ  
ХҮЧИТ ТИТЭМ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ ХҮЧИТ ТИТЭМ ХХК  
Э.БАЯРХҮҮ

УЛААНБААТАР ХОТ

20...*ц.* оны...*05* р сарын...*17*

Дугаар №. *601* / *2022*

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирай Ш.Баянмөнх/цаашид захиалагч гэх/нөгөө талаас Хүчит титэм ХХК-ийн захирал Э.Баярхүү /цаашид гүйцэтгэгч гэх/хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дах заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дах заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн A/104 дүгээр тушаал, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

- 1.1 Гэрээний зорилго нь “Зуух №3-ын их засвар” хийх ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Гэрээний нөхцөл , ерөнхий зүйл, хугацаа

- 2.1 Нийлүүлэгч нь “Зуух №3-ын их засвар” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох төсөвт заагдсан бараа, ажлыг графикт заасан хуваарийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2022 оны 08 дугаар сарын 15-нд дуусгах ба 88 хоногт багтаан гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно
- 2.2 Зуух № 2-ын их засварын ажлын баталгаат хугацаа гэрээт ажлыг бүрэн хүлээлгэн өгснөөс хойш 12 сар байна.

### Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Гэрээт ажлын үнэ нь 263,000,000/Хоёр зуун жаран гурван сая/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ нь НӨАТ багтсан мөн хуулийн 28.6-р зүйлд зааснаар татвар даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.
- 3.2 Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 /тавь/-н хувь болох 131,500,000 /Нэг зуун гучин нэгэн сая таван зуун мянга/-н төгрөгийг гэрээ баталгаажсанаас хойш ажлын 5/тав/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Хас банкны 5003247323 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийн 50 /тавь/-н хувь болох 131,500,000 /нэг зуун гучин нэгэн сая таван зуун мянга/-н төгрөгийг ажлын тайлан, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш

нэхэмжлэлийн дагуу 30 /гуч/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Хас банкны 5003247323 тоот дансанд шилжүүлнэ.

### Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1 Гэрээт ажлыг батлагдсан эзлэхүүний дагуу графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэгчийг ажлын чанараас шалтгаалан гэмтэл, доголдол гарсан нь актаар батлагдвал үнэ төлбөргүй дахин хийж гүйцэтгэж хохирлыг барагдуулна.
- 4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн ханггуулж, нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан байна. ХАБЭА-н болон галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчын шаардлагаар ажлыг зогсоноо.
- 4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөгдж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмыг мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан хууль ёсны шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа доорх баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

Ажлын төсвийн гүйцэтгэлийн тайлан	4хувь
Гэрээ дүгнэсэн протокол,акт	4хувь
Хуучин сэлбэг тушаасан баримт	4хувь
Тухайн ажилтай холбоотой бусад акт баримтууд	4хувь
Засварын өмнөх ба дараах ажлуудыг фото зургаар баримтжуулан хавсаргах	4хувь
Засвараас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяж баримтаар баталгаажуулах	4хувь

- 4.5 Ажил гүйцэтгэхд шаардлагатай бараа, автомашин, техник, багаж, тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуул хамгаалалтын ажилтанд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусад шилжүүлэхгүй байх үүрэгтэй
- 4.7 Ажил гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.
- 4.8 Ажил үйлчилгээг нэгэнт эхэлснээс хойш гэрээг цуцлах санал тавихгүй.
- 4.9 Ажил гүйцэтгэгч нь станцын хашаанд нэвтрэх түр үнэмлэх авч, захиалагчийн дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллана. Захиалагч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно.

### Тав. Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1 ХАБ, ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл, доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.
- 5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 5.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр зарим нэгэн ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

Зургаа. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -ийн алданги хүлээх ба үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэсэн ажлын чанар, техникийн гологдол, эвдрэл гарвал захиалагч нь мэдсэн буюу мэдэх боломжит өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 5 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засч хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 6.4 Компанийн дотоод дүрэм, журам зөрчих, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.5 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.6 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, төсөвт ажилбар, тээвэр механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн ямар нэгэн зөрүү гарсан тухай бүр 2 /хоёр/ тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 6.7 Уг ажлын чанарын баталгаат хугацаа 12 сар байх бөгөөд баталгаат хугацаанд гарсан гэмтлийг цаг хугацаанд нь шуурхай гүйцэтгэнэ.
- 6.8 Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.
- 6.9 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Хүчит титэм” ХХК-ийн захирал Э.Баярхүү хариуцан ажиллана. Утас-88108628.

### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сүл зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар цуцлана.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгднө.

### **Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах**

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлана.

## Ес. Бусад зүйл

- 9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР  
Э.МОНХЖАРГАЛ  
Гарын үсэг:

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ  
Ө.УДВАЛ  
Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  
Э.АРИУНБОЛД  
Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ  
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ш. ГАНТУЛГА  
Гарын үсэг:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ХҮЧИТ ТИТЭМ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
Э.БАЯРХҮҮ 1116218734 РД: 6050794  
Гарын үсэг:



Хаяг: УБ хот БЗД 21-р хороо 27, 676 тоот  
Утас: 88108628, 99108920  
РД: 6050794.



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000115370

9011597038

2016.03.01

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

/ Улсын бүртгэлийн дугаар /

6050794

/ Регистрийн дугаар /

Хүчтэй титэм

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсээн байгуулах баримт бичиг /

Тогтоол

1

2016.02.29

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

4610

Гадаад /удалдаа

/ код /

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4330

Барилгын засвар хийх

4663

Барилгын материалын худалдаа

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

3

10.00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /


/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянзүрх, 21-р хороо, сэлбийн 27, 676 тоот, Утас1: 99108920, Утас2: , Факс:


/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн өрөнхий  
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Баатар овогтой Базаррагчаа-г Захирал-р томилсныг бүртгэв.	2016.03.01	Г.Алтай 
1	Эрдэнэбаатар овогтой Баярхүү -з Захирал-р томилсныг бүртгэв.	2017.03.14	С.Мөнхсандир 

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүргэлгээ.  
Улсын бүртгэлийн гэрчилгээ заасвартай бол хүчингүй.



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

## АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 2050/20

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай”  
Монгол Улсын хуулийг үндэслэн

Улаанбаатар ..... аймаг/нийслэлийн ..... Баянзүрх ..... сум/дүүргийн  
“Хүчтэй титэм” ХХК ..... -д РД ..... 6050794  
T3-3.1, T3-4.1, T3-5.1 заалтын дагуу

..... ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг  
2020. оны 10. -р сарын 29. өдрөөс эхлэн . 3. жилийн хугацаатай олгов.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



Н.ТАВИНБЭХ

2020. оны 10. -р сарын 29. өдөр  
Улаанбаатар хот

01032

**Ажил үйлчилгээний төрөл**

- 3-3.1 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай зуухны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ
- T3-4.1 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай даралтат савны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ
- T3-5.1 0.7-16.0 кгх/см<sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ

---оо---

**Нэмэлт өөрчлөлт:**

- 3-3.2 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см<sup>2</sup>/ даралттай зуухны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ
- T3-4.2 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см<sup>2</sup>/ даралттай даралтат савны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ
- T3-5.2 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см<sup>2</sup>/ даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ

---оо---

Сайд ..... Н.ТАВИНБЭХ /

2021 оны . 01 -р сарын . 27 . өдөр

**СҮНГАЛТ:**

... оны . . . -р сарын . . . өдрөөс эхлэн . . . жилийн хугацаатай сунгав.

Сайд ..... / . . . /

.... оны . . . -р сарын . . . өдөр



Ажлын үе шатны  
ХЭСЭГЧИЛСЭН

Эхэлэл  
Төгрөг  
7 хоног

Төс, 5/17/2022  
Мөн, 8/15/2022

1


№	ҮРЛАЖИЛГАА	ХУГАЦАА	ЭХЛЭЛ	ТОГСГОЛ	DAYS	May 16, 2022	May 23, 2022	May 30, 2022	Jun 6, 2022	Jun 13, 2022
1	Эхийн шат		6/15/2022	6/30/2022						
1	Гэрээ байгуулах		5/16/2022	5/17/2022						
1	Материал захиалга		6/21/2021	5/20/2022						
1	Бэлтгэл ажил		5/23/2022	5/31/2022						
1	Зуух №3 гадна дулаалга хуулах ажил		6/2/2022	6/7/2022						
2	Зуух №3-ын галын хотолд шат барих ажил		6/6/2022	6/9/2022						
2	Зуух №3-ын хэмжүүрийн хэсгийн шугам солих ажлын шавар тойруулж буулгах		6/8/2022	6/10/2022						
2	Зуух №3-ын хэмжүүрийн хэсгийн шугам солих		6/10/2022	6/17/2022						
2	2 дахь шат									
2	Солих турба хоолойг захиалагчтай тодохойлик баталгаажуулах		5/23/2022	5/25/2022						
	Зуух №3-ын галын хотлын шавар буулгах		5/30/2022	6/10/2022						
2	Шугам хоолойг ажлын талаанд буулгах		6/18/2022	6/20/2022						
2	Ирсэн материалыг захиалагчид шалгуулж баталгаажуулах		6/20/2022	6/21/2022						
	Шугам хоолойг үгералтын ажил		6/22/2022	7/28/2022						
2	Шугам хоолойг гагнуурин ажилд хяналт шалгалтын ажил		6/22/2022	7/28/2022						
3	Шугам хоолойн усан шахалт хийх ажил		7/29/2022	7/30/2022						
3	Зуух №3 усан шахалтын акт баталгаажуулах		7/29/2022	7/30/2022						
3	3 дахь шат									
3	Зуух №3 гадна дулаалга бусаан хийх ажил		8/1/2022	8/6/2022						
3	Зуух №3 галын хотол шавар хийх ажил		8/1/2022	8/6/2022						
3	Коммис ажиллуулах		8/8/2022	8/9/2022						
3	Зуух №3 -ын галын хотолд хийгдсэн түр шат тавцан буулгах ажлын байрь цэвэрлэж хүлээлцэх		8/9/2022	8/14/2022						
4	Бичиг баримт хүлээлцэх	8/10/2022	8/12/2022							
4	Гэрээ дутгэнх	8/15/2022	8/15/2022							

ХЯНАСАН  
ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА



Э.АРИУНБОЛД  
Э.БАЯРХҮҮ

БОЛОВСРУУЛСАН  
ХҮЧИТ ТИТЭМ ХХК-ИИН ЗАХИРАЛ

АДС ТӨХК-ИИН ЗУУХАН ЦЕХИЙН  
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР   
Л.ЭРДЭНЭХҮҮ

Ажиллах өдөр  
Амрах өдөр  
Бүх нийтээр амарах өдөр  
Материал худалдан авалт,  
нийлүүлэлт

